

## 8

## ҮНИЙН СТАТИСТИКИЙН ҮҮРЭГ РОЛЬ

## Б.Сарангэрэл, Ц.Тэгшжаргал

Зах зээлийн эдийн засгийн харилцаа гэдэг нь нийгмийн эдийн засгийн амьдралыг зохион байгуулах нэгэн арга хэлбэр юм. Зах зээлийн эдийн засгийн үед үнэ нь эрэлт нийлүүлэлтийн харьцаагаар зохицуулагдаж байдаг. Зах зээлийн өөрчлөлтийн нөхцөлд хэрэглэгчид өөрсдийн зарлагаа байнга өөрчилж байдгаас гадна хүн амын зарим бараа, үйлчилгээний хэрэглээний бүтцэд чухал өөрчлөлтүүд ордог. Үнийн динамик, түвшин түүний төрөл ангийн хоорондын харьцаа нь улс орны эдийн засаг, үйлдвэр аж ахуйн нэгжийн бүтээгдэхүүн болон ашигт ажиллагаа, ард түмний амьдралд тодорхой хэмжээгээр нөлөөлөл үзүүлдэг юм. Эдгээр өөрчлөлт, нөлөөллийг үнийн статистик нарийвчлан судалдаг. Үнийн түвшний өөрчлөлтийг хэмжихэд хэрэглээний үнийн ерөнхий индексийг ашигладаг Энэ индекс нь хүн амын амьдралын өртгийн өөрчлөлтийг судлах, улсын болон хувийн байгууллага, аж ахуйн нэгжүүд ажиллагсдынхаа цалин хөлсийг үнийн өсөлттэй уялдуулан тогтоох, тэтгэвэр, тэтгэмжид зохицуулалт хийх, инфляцын түвшний өөрчлөлтийг тооцох, зээлийн хэмжээ болон зээлийн хүүг инфляцын түвшинтэй уялдуулан тогтоох түүнчлэн үндэсний тооцооны зарим үзүүлэлтүүдийг зэрэгцүүлэх үнээр үнэлэхэд ашигладаг.

Инфляци нь макро эдийн засгийн хамгийн чухал үзүүлэлтүүдийн нэг юм. Инфляц өслөө гэдгийг барааны үнэ өслөө гэж ойлгож болохгүй. Инфляц явагдана гэдэг нь бүх үнүүд өсч байна гэсэн үг хараахан биш юм. Зарим үнэ өсч байхад зарим нь буурч байдаг. Үнийн индексийг тооцохдоо бүх бараа үйлчилгээний үнийг бус, өргөн хэрэглэгддэг бараа, үйлчилгээний үнэ тарифыг түүвэрлэн оруулдаг. Үндэсний Статистикийн Газар нь Хэрэглээний Үнийн Индексийг тооцохдоо 239 нэр төрлийн бараа, үйлчилгээний үнийн өөрчлөлтийг авч судалдаг. Үнийн судалгаагаар дараах үндсэн зорилтуудыг шийддэг.

- Бараа нэг бүрийн болон барааны бүлэг бүрийн үнийн динамик түвшинг байнга ажиглан судлах
- Барааны дундаж үнийг тооцоолох
- Бараа болон түүний бүлгийн үнийн хоорондын харьцаа уялдааг судлах
- Бүтээгдэхүүнийг зэрэгцүүлэх үнээр тооцон, үнийн болон биет хэмжээний индексийг тооцох

Дэлхийн хэмжээний эдийн засгийн бүтцэд гарсан хоёр томоохон өөрчлөлтөөс болж ХХ зууныг инфляцийн зуун гэж нэрлэдэг. Тэр өөрчлөлтийн нэг нь шинжлэх ухаан технологийн дэвшлийг дагалдан ихэнх оронд зах зээлийн чөлөөт өрсөлдөөн хумигдаж олигополь бүтэц зонхилох болсон, хоёрдахь нь үнэт метал мөнгөний үүрэг гүйцэтгэхээ больж санхүү мөнгө зээлийн тогтолцоо үндсээрээ өөрчлөгдсөн явдал юм.

Мөнгөний нийлүүлэлт түүний илүүдэл хомсдолоос шалтгаалахгүйгээр, нийгмийн хэмжээгээр хөдөлмөрийн бүтээмж өөрчлөгдөх, нийгмийн үйлдвэрлэлийн бүтэц шинэчлэгдэх, зах зээл монопольчлогдох гадаад худалдааны нөхцөл байдал өөрчлөгдөх зэрэг олон шалтгааны улмаас барааны үнэ, үйлчилгээний тариф ерөнхийдөө өсөх хандлагатай болж байна. Чөлөөт зах зээлийн үед үнийн өсөлт нь нийлүүлэлтийг өдөөж, эрэлт нийлүүлэлтийн харьцаагаар үнийн түвшин өөрчлөгдөж байдаг. Энэ үнийн хэлбэлзлэлийг инфляци гэж авч үзэж болохгүй. Байгалийн гамшгаас болж тодорхой барааны үнэ өсөх, эсвэл үнийн улирлын чанартай хэлбэлзлэлийг инфляцаас шалтгаалсан үнийн өсөлт гэж үздэггүй. Харин нийгмийн хэмжээгээр нөхөн үйлдвэрлэлийн тэнцвэр алдагдан нийгмийн нийт эрэлт, нийт нийлүүлэлтээс давж, зонхилох барааны үнэ, үйлчилгээний тарифын ерөнхий түвшин өсвөл түүнийг инфляци гэж тодорхойлж болно. Гэхдээ зарим тодорхой нэрийн барааны зах зээлийн тэнцвэр алдагдах явдал нь улс орон, бүс нутаг, түүгээрч барахгүй дэлхийн хэмжээнд эдийн засгийн ерөнхий тэнцвэрийг эвдэхэд хүргэдэг байна. Эндээс үндэслэн инфляцаас шалтгаалсан үнийн өсөлтийг дараах байдлаар дүгнэж болно.

1. Төрийн буруу бодлого нь инфляцийг өдөөгчийн үүрэг гүйцэтгэнэ.
2. Чөлөөт өрсөлдөөнт зах зээлийн эрин дуусч, монопольчлол нэг улсын хүрээнээс хальж, зарим үед улс төртэй сүлбэлдэх болсон явдал нь нийлүүлэлтийг зохиомлоор хязгаарлан, үнийг хяналтанд оруулж, зах зээлд ноёрхлоо хадгалахын тулд хиймэл хомсдол үүсгэн нийгмийн нийт эрэлт нийт нийлүүлэлтийн тэнцвэрийг алдагдуулахад хүргэдэг. Өөрөөр хэлбэл зах зээлийн хөгжил инфляцийг өдөөгч болох тохиолдол байдаг.
3. Улс орнуудын эдийн засаг улам бүр нээлттэй болж, харилцан хамаарал нь нягтрахын хирээр инфляци импортлогдох хандлагатай болж байна. Энэ нь аль нэг орны үндэсний мөнгөн тэмдэгт тогтвортой мэт байлаа ч гэсэн импортоор авч байгаа барааны үнийн



хэлбэлзлэлээс хамааран барааны үнэ хөдлөх тохиолдол байнга гардаг. Үнийн ийм хөдөлгөөн газар авахын хирээр тухайн орны мөнгөн тэмдэгтийн ханш зайлшгүй хөдөлж байдаг.

Үнийн өсөлтийн эдгээр хүчин зүйлээс гадна "инфляцийн хүлээлт"-ээс шалтгаалсан үнийн өсөлт байдаг. Барааны үнэ, үйлчилгээний тариф үргэлжлэн өсөх тохиолдолд хүмүүс үнэ хямдарна, тогтворжино гэж итгэхгүйгээс болж хэрэгцээнээсээ илүү бараа худалдан авч нөөцлөх тохиолдол гардаг. Ингэснээр хадгаламжинд байсан мөнгө гүйлгээнд гарч мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ арилжааны банкны зээлийн эх үүсвэрийг хомсдолд оруулж, нийлүүлэлтийг нэмэгдүүлэх боломжийг хязгаарладаг. "Инфляцийн хүлээлт"-ээс шалтгаалсан үнийн өсөлт нь 1990-ээд оноос хойш шилжилтийн эдийн засгийн орнуудад үзэгдлийн шинжтэй байв. Зах зээлийн эдийн засгийн харилцаа зүгширч эдийн засаг тогтворжихын хирээр инфляцийн энэ хүчин зүйлийн үйлчлэл аажмаар багасна. Инфляци нь эдийн засгийн амьдралын байнгын хүчин зүйл болж, эдийн засгийн харилцааны ерөнхий тогтолцоонд ихээхэн төвөг учруулдаг. Инфляцийн түвшин түүний нөлөөллийн хэмжээнээс бүхэл нийгэм болон эдийн засаг шалтгаалдаг.

Ихэнх эдийн засагчид мөнгөний нийлүүлэлт нь үнийн түвшин, нэрлэсэн цалингийн түвшин зэрэг нэрлэсэн хүчин зүйлүүдэд урт хугацааны турш нөлөөлдөг учраас мөнгөний бодлогын гол зорилт нь нэрлэсэн хүчин зүйл байх нь зүйтэй гэж үздэг. Өөрөөр хэлбэл мөнгөний өсөлт нь үнийн өсөлттэй байнга холбоотой байдаг нь тодорхой учраас мөнгөний нийлүүлэлт нь өсч байгаа тохиолдолд үнийн түвшний өсөлтийн хүлээлт бий болж, богино хугацаанд биш юмаа гэхэд урт хугацаанд үнийн түвшин өсөх нь гарцаагүй байдаг гэж үздэг. Тийм учраас бодлого тодорхойлогчид нь эдийн засгийн өсөлт, үнийг хязгаарлах, гадаад худалдааны тэнцвэржилтийг хангах, ажилгүйдлийг бууруулах, төсвийн тэнцлийг тогтворжуулахад дэмжлэг үзүүлэх зэрэг олон зорилтыг мөнгөний бодлогоор дамжуулан нэгэн зэрэг хэрэгжүүлэх гэж оролдсоноос мөнгөний нийлүүлэлтийг хянаж чадаж байвал үнийн түвшний өсөлтийг хянаж, бодлогын хувьд тодорхой үр дүнд хүрэх бололцоотой болох юм.

Ерөнхийдөө бодлогын гол гол зорилтууд хоорондоо зөрчилтэй байж, бодлого боловсруулагчдад байнга сонголт хийх шаардлага гардаг тул инфляцыг гол зорилго болгон тодорхойлсноор бодлогын сонголтуудыг гол зорилт дээрээ төвлөрүүлэх боломжтой юм.

Инфляцийн түвшинг гол зорилго болгон зарласнаар хүмүүсийн хүлээлтэнд эерэгээр нөлөөлөн банкинд итгэх итгэлийг сайжруулахад чухал нөлөөтэй гэж үздэг.

Үнийн жилийн өсөлтийн хурдыг харгалзан инфляцийг мөлхөө, хүчтэй, хэт(гипер) гэсэн гурван төрөлд хуваадаг.

Үнэ тариф жилд ерөнхий дүнгээрээ 20-иос хэтрэхгүй, дунджаар 10 орчим буюу түүнээс арай бага өсч байвал мөлхөө инфляци гэдэг. Үнийн жилийн дундаж өсөлт 20-200 хувьд байвал түүнийг хүчтэй инфляци гэнэ. Үнийн өсөлт жилдээ 200 хувиас дээш гарвал түүнийг хэт (гипер) инфляци гэнэ.

Манай орны хувьд эдийн засгийн шилжилтийн эхний жилүүдэд инфляцийн түвшин өндөр байлаа. Жилийн инфляци 1992 онд 325 хувьд хүрсэн нь хамгийн өндөр түвшин байсан бөгөөд түүнийг хэт инфляци, 1993 онд 183 хувьд хүрснийг хүчтэй инфляци гэж хэлж болно.

Монгол улсын хувьд тухайн үед инфляцийн өндөр өсөлтөнд нийлүүлэлтийн шокоор дамжуулан үйлдвэрлэлтийн уналт зохих нөлөө үзүүлсэн. Хуучин ЗХУ болон ЭЗХТЗ задарснаар Монгол улсын үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, материалын нийлүүлэлт үндсэндээ зогсож, нийлүүлэлтийн мэдрэмжийг багасгаж эрэлтийг нэмэгдүүлсэн. Энэ нь Монгол орны хувьд инфляцийг хөөрөгдөх, үйлдвэрлэлийн сэргэлтийг удаашруулах гол шалтгаан болсон. Барууны эдийн засагт инфляцийг, үйлдвэрлэлийг сэргээх нэг хэрэгсэл болгон ашигладаг тохиолдлууд байдаг боловч Монголын нөхцөлд энэхүү арга тэр болгон тохирдоггүй юм. Харин монголын нөхцөлд инфляцийн өсөлт нь засгийн газар, улсын үйлдвэр аж ахуйн газрууд болон банкны салбарын хооронд тогтсон өмнөх үеийн харилцаанаас үүдэлтэй юм. Тухайлбал улсын төсвийн орлого, зарлага нь улсын үйлдвэр, аж ахуйн газруудтай нягт уялдаатай байхын зэрэгцээ үнийг дээрээс нь хянах тогтолцоотой байв. Барууны эдийн засагт зонхилдог татварын орлого (орлого, худалдааны, нэмэгдсэн өртгийн зэрэг) нь төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцооны үед төдийлөн үүрэг ач холбогдолгүй байдаг. Нөгөө талаас улсын хөрөнгө оруулалт төсвөөс санхүүжүүлэгддэг байв. Банкны тогтолцоо нь зээлийг ямар нэгэн эрсдэлийн болон бусад тооцоо судалгаагүй, зөвхөн олгох үүргийг л гүйцэтгэж иржээ. Шилжилтийн эхний үед эдийн засгийн хамтын ажиллагааны хэлбэр өөрчлөгдснөөс гадна татварын тогтолцоо шинэчлэгдсэнээр улсын төсөвт зарим хүндрэл үүссэн. Шилжилтийн эхний үед банкны хуучин механизм үйлчилсэн хэвээр байсан учир улсын үйлдвэр аж ахуйн газарт ямар нэгэн судалгаагүй их хэмжээний зээлийг олгов. Мөн өмч хувьчлалыг удаашруулсан явдал ч инфляцийг өсгөх нэг үндэс болж байсан юм..

1991 оны 1-р сард үнийг 2 дахин нэмэгдүүлсэн явдал Монголын бараа, бүтээгдэхүүний үнийг дэлхийн зах зээлийн үнийн түвшинтэй ойртуулахад чиглэгдсэн алхам байсан боловч инфляцийг хөөрөгдөх нэг үндэс болж байсан. Мөн дараачийн онуудад хийгдсэн зарим бараа, үйлчилгээний үнийг чөлөөлөх үйл явц нь ч инфляцийг нэмэгдүүлэхэд зохих үр дагавар үзүүлсэн юм.

1990-ээд оны эхээр инфляцийн өсөлт нь М1, М2-ын өсөлтөөс нилээд өндөр байв. 1992 онд инфляци 325 хувьд хүрч байхад М1 зөвхөн 4.3 хувь, М2 31.6 хувиар тус тус нэмэгдсэн байна. Харин 1993 онд инфляци 183 хувь болон буурахад М1, М2 -ын хэмжээ 143 хувь, 228 хувиар тус тус өсөв. Энэ нь үнийн либералчлал, үнийн өсөлт ба мөнгөний нийлүүлэлтэнд хэрхэн нөлөөлснийг тодорхой харуулж байна.

Экспортын хэдхэн нэр төрлийн бүтээгдэхүүнээс хамааралтай нээлттэй эдийн засагтай Монгол шиг жижиг орны хувьд валютын ханшны талаарх баримтлах бодлого нь нилээн чухал юм. 1993 онд валютын ханшийг чөлөөлсөн нь мөнгөний ханш унахад тодорхой хэмжээгээр нөлөөлсөн боловч хар зах



болон албан ханшийг нилээн ойртуулсан арга хэмжээ болсон байна. Нөгөө талаас энэ алхам нь инфляцыг хянах нэг механизм болсон. Монгол банкны судалгаагаар ханшны өөрчлөлт нь үнийн түвшинд шууд тусгалаа олж байдаг ба 1992-2000 оны төгрөг, ам. долларын ханшны өөрчлөлт болон жилийн инфляцийн хоорондох корреляцийн хамаарал нь маш өндөр гэсэн тооцоог хийсэн байна. Өргөн хэрэглээний ихэнх бараагаа гаднаас импортоор авдаг манай орны хувьд импортын барааны үнэ нь манай улсын инфляцид мөн мэдэгдэхүйц хэмжээгээр нөлөөлдөг ба худалдааны түншүүдийн инфляци 1 пунктээр нэмэгдэхэд монголын инфляци 0.89 нэгжээр өснө гэсэн тооцоог монгол банкны судлаачид хийсэн байна.

90-ээд оны сүүл үеэс мөнгөний нийлүүлэлт, хөрөнгө оруулалтыг хязгаарлаж, хадгаламжийн богино зээлийн хүүг өндөр түвшинд барих зэргээр мөнгөний хатуу бодлого явуулсны дүнд инфляци аажмаар буурч, эдийн засаг сэргэж эхэлж байна. Инфляцийн түвшин тухайн жилийн сар сараар нилээд ялгаатай байгаа нь нийлүүлэлтийн улирлын чанартай хэлбэлзэл, хэрэглээний сагсанд сонгосон бараа үйлчилгээний хувийн жингээр тайлбарлагдана. 2002 онд инфляцийн жилийн дундаж өсөлт 1.6 орчим хувьтай байлаа.

Сүүлийн жилүүдэд инфляци тогтворжих хандлагатай болсноор банкны салбарын үйл ажиллагаа идэвхжиж, зээл хадгаламжийн хэмжээ илт өсч, банк бус санхүүгийн байгууллагууд олноор бий болж байна. Хүмүүсийн банкинд итгэх итгэл нь тэдний эдийн засгийн цаашдын хандлагын талаарх хүлээлттэй холбоотой байдаг. Банкны салбарын үйл ажиллагаа тогтворжихийн хэрээр иргэд, бизнес эрхлэгчдийн банкинд итгэх итгэл бий болж, их хэмжээний мөнгө, харилцах, хадгаламжийн хэлбэрээр банк руу орж, тэр хэмжээгээр хувь хүмүүсийн бизнес эрхлэхэд нь зээл олгож, үйлдвэр, аж ахуйн газруудад хөрөнгө оруулалт хийгдэх болсон зэрэг нь дотоодын хуримтлалыг бий болгож, эдийн засгийн сэргэлтэд нөлөөлж байна.